

PLITONIT

МЭРГЭЖИЛТЭН БАЙХ АМАРХАН



PLITONIT СуперПол PROFI – шалыг тэгшлэхэд зориулсан материалыг ашиглахын өмнө хэрэглэх тусгай гүн нэвтрэдэг баяжмал- хөрсжүүлэгч



Уг бүтээгдэхүүн нь суурийн барьцалдуулагч чадварыг нэмэгдүүлэх, ус шингээлтийг багасгах, дотор болон гадна ажил хийхээс өмнө тэгшлэгчээс усыг хугацаанаас нь өмнө зайлуулах, суурийн тоосжилтыг арилгах зорилгоор цементэн болон гөлтгөнө цементэн суурьтай шал тэгшлэгч хэрэглэхийн өмнө цементэн суурьтай шалыг хөрсжүүлэх зориулалттай.

Шалны тусгай хөрсжүүлэгч учир суурь уруу нэвтрэх өндөр чадвартай энэ нь 2 ба түүнээс дээш түрхэхэд суурийн гадаргууд хальсан давхарга үүсэж, зуурмагийн тархалт сайжирдаг. Мөн шохой, шавардлага, цавууны хольцыг хэрэглэхээс өмнө хана, таазыг энэ бүтээгдэхүүнээр боловсруулж болно.

Савлагаа — 3 л, 10 л хэмжээтэй хуванцар канистр.

- Баяжмал
- 1:3 хүртэл шингэлэх харьцаатай
- Гүн нэвтрэх
- Тэгшлэх хольцыг илүү хялбар тараахын тулд гадаргуу дээр хальс үүсгэдэг
- Гадна болон дотоод заслын хөрсжүүлэх ажилд зориулсан

Бүтээгдэхүүний зарцуулалт

Суурийн шингээх чадвараас хамааран шингэлээгүй хөрсжүүлэгч 1 м² тутамд 45-100 мл зарцуулагдана

Ажлын нөхцөл

Ажлын явцад агаарын болон суурийн температур хамгийн багадаа +5 ° C байх ёстой. Гаднах ажлыг гүйцэтгэхдээ боловсруулсан гадаргууг хатах хүртэл хур тунадаснаас хамгаалах шаардлагатай.

Гадаргууг бэлтгэх

Хөрсжүүлэхийн өмнө гадаргууг тоос, шороо, өөх тосноос цэвэрлэнэ. Хуучин болон муу тогтсон сул хэсгүүдийг сайтар арилгах хэрэгтэй. Гөлтгөнө, сульфат кальцийн, түүнчлэн сул шингээдэг суурийн гадаргууг барьцалдуулагч давхарга үүсгэх тулд дүүргэгч бодисын мөхлөг гартал зүлгүүрээр зүлгэнэ.

Хэрэглэх заавар

Баяжмалыг шингэлэхдээ энгийн ундны усыг ашиглана. Шингэрүүлэн хэрэглэхийн өмнө сайтар холино. Хүснэгтийн дагуу пропорцоор усаар шингэлнэ.

Гадаргуугийн төрөл, хөрсжүүлэгчийн онцлог	Шингэлэх пропорц (хөрсжүүлэгч: ус)
гөлтгөнө, сульфат кальцийн эсвэл гөлтгөнө хавтан агуулсан гадаргуу (хоёр давхаргаар түрхэх)	1:2
сул шингээдэг гадаргуу	1:3

Багс, бул, сойз эсвэл шүршигчээр түрхэж, завсар, шалбааг үүсэхээс сэргийлнэ. Хэрэв хөрсжүүлэгч суурь уруу 5-10 минутын дотор шингэж, хатсан бол дахин хөрсжүүлэг хийх шаардлагатай. Эхний давхаргыг түрхсэнээс хойш ойролцоогоор 1 цагийн дараа давтан хөрсжүүлэгчийг давтан хэрэглэнэ. Сүүлийн хөрсжүүлэгч давхаргыг хэрэглэснээс хойш 1 цагийн өмнө тэгшлэгч давхаргыг тавихыг зөвшөөрнө. Хатаасны дараа хөрсжүүлэгч давхаргын гадаргуу дээр наалдамхай үлдэгдэл байж болох бөгөөд энэ нь дараагийн бүрэх давхаргыг тавихад саад болохгүй.

Аюулгүй ажиллагаа

Ажил гүйцэтгэхдээ бээлий хэрэглээрэй. Хөрсжүүлэгчийг арьс, нүдэнд хүрэхээс зайлсхийгээрэй. Нүдэнд хүргэсэн тохиолдолд нэн даруй их хэмжээний усаар зайлна. ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГА!

Анхааруулга

Хэрэглэсний дараа багаж, савыг усаар зайлж угаана. Дээр заагдсан шинж чанарууд нь орчны температур (20 ± 2)°C, агаарын харьцангуй чийгшил (60 ± 10)%-д үйлчилнэ. Ажлыг гүйцэтгэхдээ барилгын ерөнхий ажил гүйцэтгэх зааварчилга, барилга угсралтын ажилд мөрдөгдөх аюулгүй ажиллагааны зааварчилга дагаж мөрдөх ёстой.

Орц, найрлага

Полимерын усан дисперс, сайжруулсан нэмэлтүүд.

Тээвэрлэлт болон хадгалах нөхцөл

Нарны шууд тусгалаас хамгаалсан, сайтар битүүмжилсэн саванд -50°C-аас +40°C-ийн температурт хадгална. -50 хэмд 5 хүртэл удаа хөлдөөхийг зөвшөөрдөг, гэсгээсний шинж чанараа хадгалдаг. Нэмэлт халаалт ашиглалгүй тасалгааны температурт бүрэн гэсэх хүртэл гэсгээнэ. Задлан нээгээгүй бүтээгдэхүүний хадгалах хугацаа нь үйлдвэрлэсэн өдрөөс хойш 24 сар байна.

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч тээвэрлэх, хадгалах нөхцөл, энэхүү гарын авлагад заасан зааврыг дагаж мөрдсөн тохиолдолд шаваас нь техникийн үзүүлэлтүүдийн шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулна. Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй.

3 кг канистртай бүтээгдэхүүний хувьд логистикийн мэдээлэл

Хувийн бар-код 4607013047785

Бүлгийн бар-код 14607013047782

Хайрцагт агуулагдах канистрын тоо 6 ширхэг

Нэг багц дахь канистрын тоо – 144 ширхэг

10 л канистртай бүтээгдэхүүний хувьд логистикийн мэдээлэл

Хувийн бар-код 4607013047778

Нэг багц дахь канистрын тоо – 40 ширхэг